



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/138-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсрол ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОУБ	Олон улсын байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Р.ЦОЛМОН ТАНАА

2025.02.25 № СМА-2025/138-НА-СТА-ТМЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 27,082.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	243,903,586.38	388,318,207.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	168,422,455.13	295,271,108.94
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	168,422,455.13	295,271,108.94
31210	Төгрөг	168,422,455.13	295,271,108.94
31211	Төрийн сангийн харилцах	168,422,455.13	295,271,108.94
33	АВЛАГА	0.00	0.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,481,131.25	93,047,099.05
351	Түүхий эд материал	7,270,840.57	13,806,798.37
35400	Хангамжийн материал	68,210,290.68	79,240,300.68
3541	Бичиг хэргийн материал	842,000.00	544,200.00
3542	Аж ахуйн материал	551,800.00	541,400.00
3544	Түлш, шатах тослох материал	0.00	216,000.00
3546	Хүнсний материал	450,790.00	2,771,900.00
3547	Бусад хангамжийн материал	66,365,700.68	75,166,800.68
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,210,162,426.38	2,190,527,680.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,210,162,426.38	2,190,527,680.72
39200	Биет хөрөнгө	2,083,552,426.38	2,064,247,680.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,673,000,000.00	1,673,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,277,777.74)	(78,944,444.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	181,028,728.94	270,039,753.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,167,286.20)	(77,194,243.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,177,200.00	178,573,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,393,670.91)	(79,114,497.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	193,358,300.00	193,358,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,199,192.01)	(20,789,295.62)
39217	Ном	4,026,124.30	5,318,907.20
39300	Биет бус хөрөнгө	126,610,000.00	126,280,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(440,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	125,400,000.00	125,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,454,066,012.76	2,578,845,888.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,454,066,012.76	2,578,845,888.71
51	Засгийн газрын хувь оролцоо	2,454,066,012.76	2,578,845,888.71
51100	Засгийн газрын оруулсан капитал	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,454,066,012.76	2,578,845,888.71
51210	Өмнөх үеийн үр дүн	2,454,066,012.76	2,454,066,012.76

51220	Тайлант үеийн үр дүн	0.00	124,779,875.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,454,066,012.76	2,578,845,888.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,213,829,128.40	2,032,891,552.77	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,875,640.60	74,078,265.70	
120	Нийтлэг татварын бус орлого	34,875,640.60	74,078,265.70	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,866,780.00	8,177,400.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,085,100.00	1,577,400.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,781,680.00	6,600,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,026,827.50	59,604,907.90	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,982,033.10	6,295,957.80	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,178,953,487.80	1,958,813,287.07	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,138,713,000.00	1,867,522,900.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,138,713,000.00	1,867,522,900.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	0.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	0.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,240,487.80	91,290,387.07	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,240,487.80	91,290,387.07	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,200,799,239.44	1,908,111,676.82	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,799,239.44	1,908,111,676.82	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,121,799,709.44	1,809,112,096.82	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	831,667,821.76	1,354,298,523.01	
210101	Үндсэн цалин	623,853,850.74	863,840,680.45	
210102	Нэмэгдэл	181,815,687.81	427,207,956.06	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,998,283.21	63,249,886.50	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,131,594.12	160,667,867.63	
210201	Тэтгэврийн даатгал	72,349,789.01	108,823,364.00	
210202	Тэтгэмжийн даатгал	8,424,711.53	13,162,350.11	
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,616,569.12	6,867,660.95	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,430,956.33	6,363,038.53	
210205	Эрүүл мэндийн даатгал	14,309,568.13	25,451,454.04	

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,208,737.80	33,181,787.07
210301	Гэрэл, цахилгаан	15,196,237.80	15,670,777.07
210302	Түлш, халаалт	14,250,000.00	15,909,000.00
210303	Цэвэр, бохир ус	937,500.00	1,102,010.00
210304	Байрны түрээс	825,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2,316,300.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,316,300.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,572,150.00	57,892,600.00
210604	Урсгал засвар	4,572,150.00	57,892,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,780,955.00	21,884,409.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,780,600.00	1,337,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000,355.00	20,547,009.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,438,450.76	178,870,609.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,660,821.50	45,696,356.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,537,600.00	13,839,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,240,029.26	119,334,553.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,999,530.00	98,999,580.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,999,530.00	98,999,580.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,477,230.00	81,396,180.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,522,300.00	17,603,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,029,888.96	124,779,875.95
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	13,029,888.96	124,779,875.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,190,820,267.80	1,966,990,687.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,866,780.00	8,177,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,866,780.00	8,177,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,866,780.00	8,177,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,085,100.00	1,577,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,781,680.00	6,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,178,953,487.80	1,958,813,287.07
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,138,713,000.00	1,867,522,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,138,713,000.00	1,867,522,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	0.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,240,487.80	91,290,387.07
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,240,487.80	91,290,387.07
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,098,488,300.18	1,802,447,133.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,098,488,300.18	1,802,447,133.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,019,055,480.18	1,701,126,443.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	831,667,821.76	1,354,298,523.01
210101	Үндсэн цалин	623,853,850.74	863,840,680.45
210102	Нэмэгдэл	181,815,687.81	427,207,956.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	25,998,283.21	63,249,886.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,131,594.12	160,667,867.63
210201	Тэтгэврийн даатгал	72,349,789.01	108,823,364.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,424,711.53	13,162,350.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,616,569.12	6,867,660.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,430,956.33	6,363,038.53
210205	Эрүүл мэндийн даатгал	14,309,568.13	25,451,454.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,362,737.80	33,397,787.07
210301	Гэрэл, цахилгаан	15,196,237.80	15,670,777.07
210302	Түлш, халаалт	14,250,000.00	16,125,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,091,500.00	1,102,010.00
210304	Байрны түрээс	825,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,112,750.00	57,892,600.00
210604	Урсгал засвар	5,112,750.00	57,892,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,780,955.00	27,744,409.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,780,600.00	1,337,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000,355.00	26,407,009.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,999,621.50	67,125,256.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,063,221.50	50,875,856.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,936,400.00	16,249,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,432,820.00	101,320,690.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,432,820.00	101,320,690.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,910,520.00	83,717,290.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,522,300.00	17,603,400.00

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	92,331,967.62	164,543,553.81
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	71,517,950.00	37,694,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,517,950.00	37,694,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	71,517,950.00	37,694,900.00
222001	Тоног төхөөрөмж	56,443,950.00	28,298,900.00
223001	Бусад хөрөнгө	15,074,000.00	9,396,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(71,517,950.00)	(37,694,900.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	20,814,017.62	126,848,653.81
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		168,422,455.13
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		295,271,108.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,441,036,123.80	2,441,036,123.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,029,888.96	13,029,888.96
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,454,066,012.76	2,454,066,012.76
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
17	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	124,779,875.95	124,779,875.95
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,578,845,888.71	2,578,845,888.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,137,964,500.00	1,840,142,033.26	297,822,466.74	86.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,137,964,500.00	1,840,142,033.26	297,822,466.74	86.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,030,707,600.00	1,701,126,443.26	329,581,156.74	83.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,576,397,200.00	1,354,298,523.01	222,098,676.99	85.9
210101	Үндсэн цалин	995,085,300.00	863,840,680.45	131,244,619.55	86.8
210102	Нэмэгдэл	535,409,700.00	427,207,956.06	108,201,743.94	79.8
210104	Урамшуулал	45,902,200.00	63,249,886.50	(17,347,686.50)	137.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	197,049,600.00	160,667,867.63	36,381,732.37	81.5
210201	Тэтгэврийн даатгал	133,993,700.00	108,823,364.00	25,170,336.00	81.2
210202	Тэтгэмжийн даатгал	15,764,000.00	13,162,350.11	2,601,649.89	83.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,882,000.00	6,867,660.95	1,014,339.05	87.1
210204	Ажилгүйдлийн даатгал	7,882,000.00	6,363,038.53	1,518,961.47	80.7
210205	Эрүүл мэндийн даатгал	31,527,900.00	25,451,454.04	6,076,445.96	80.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,153,100.00	33,397,787.07	4,755,312.93	87.5
210301	Гэрэл, цахилгаан	16,822,200.00	15,670,777.07	1,151,422.93	93.2
210302	Түлш, халаалт	17,100,000.00	16,125,000.00	975,000.00	94.3
210303	Цэвэр, бохир ус	3,230,900.00	1,102,010.00	2,128,890.00	34.1
210304	Байрны түрээс	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0
2105	Нормативт зардал	0.00	0.00	0.00	
210502	Хоол, хүнс	0.00	0.00	0.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,892,600.00	57,892,600.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	57,892,600.00	57,892,600.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,428,100.00	27,744,409.55	15,683,690.45	63.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,337,400.00	1,337,400.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,090,700.00	26,407,009.55	15,683,690.45	62.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,787,000.00	67,125,256.00	50,661,744.00	57.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,537,600.00	50,875,856.00	50,661,744.00	50.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,249,400.00	16,249,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,256,900.00	101,320,690.00	5,936,210.00	94.5
2132	Бусад урсгал	107,256,900.00	101,320,690.00	5,936,210.00	94.5

	шилжүүлэг				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	89,653,500.00	83,717,290.00	5,936,210.00	93.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,603,400.00	17,603,400.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	37,694,900.00	(37,694,900.00)	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	37,694,900.00	(37,694,900.00)	
222001	Тоног төхөөрөмж	0.00	28,298,900.00	(28,298,900.00)	
223001	Бусад хөрөнгө	0.00	9,396,000.00	(9,396,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,137,964,500.00	1,966,990,687.07	170,973,812.93	92.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,867,522,900.00	1,867,522,900.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,867,522,900.00	1,867,522,900.00	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	96,045,700.00	91,290,387.07	4,755,312.93	95.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	174,395,900.00	8,177,400.00	166,218,500.00	4.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,337,400.00	1,577,400.00	(240,000.00)	117.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,600,000.00	6,600,000.00	0.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	166,458,500.00	0.00	166,458,500.00	0.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		168,422,455.13	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		295,271,108.94	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь “Сургуулийн менежментийг сайжруулах, боловсролын үйлчилгээний чанарт ахиц амжилт гаргах” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиудыг судлан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтан, иргэд олон нийтэд сурталчлан таниулж, тэдний оролцоотой хэрэгжүүлэх,
- Хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлж, сургуулийн орчинд аливаа хэлбэрийн гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс сэргийлэх,
- Багш ажлын байрандаа мэргэжил боловсролоо дээшлүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж, багшийн мэдлэг, ур чадварт гарсан ахиц үр дүнг тооцох,
- Суралцагчдыг эрүүл амьдрах зөв дадал хэвшилд сургаж, аливаа гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт,

шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 124,779.9 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	168,422.5	295,271.1	126,848.6
Бараа материал	75,481.1	93,047.1	17,566.0
Үндсэн хөрөнгө	2,210,162.4	2,190,527.7	(19,634.7)
Нийт хөрөнгө	2,454,066.0	2,578,845.9	124,779.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,454,066.0	2,578,845.9	124,779.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,454,066.0	2,578,845.9	124,779.9

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 295,271.1 мянган төгрөг болж 123,848.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 93,047.1 мянган төгрөг болж 17,566.0 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 4,817.4 мянган төгрөгийн ном, Ай И Ди Си ХХК-аас 1,478.6 мянган төгрөгийн хэвлэмэл болон цахим сурах бичиг үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 146,498.0 мянган төгрөгийн материал бэлтгэн, сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалаар 2,316.3 мянган төгрөгийн бараа материал акталж, 132,911.7 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаанд зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,447,340.2 мянган төгрөг болж 99,699.9 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-с 41,044.1 мянган төгрөгийн ном, зөөврийн компьютер, тоног төхөөрөмж, Дезерэт ОУБ-с 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, иргэн М.Долгорсүрэнгээс 1,159.0 мянган төгрөгийн зурагт төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 40,095.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 119,334.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,392,665.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 46,045.7 мянган төгрөг, нийт 1,438,711.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 51,493.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 23,111.7 мянган төгрөгөөр нийт 74,604.7 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 39,669.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 25,773.5 мянган төгрөгөөр нийт 65,443.1 мянган төгрөгөөр буруулж нийт төсвийг 1,447,872.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 595,228.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 5,512.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 25,706.9 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 13,643.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 50,000.0 мянган төгрөгөөр нийт 690,091.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,873,496.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 96,045.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 168,422.4 мянган төгрөг буюу төсвийг нийт **2,137,964.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 2,137,964.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,840,142.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,840,142.0 мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь үдийн цай хөтөлбөрийн зардлыг 5,936.4 мянган төгрөг, үйл ажиллагааны зардлыг 291,886.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,161.3	4,161.3	-	100.0
		2	80312- Сургалт семинар	4,478.1	3,175.2	1,302.8	70.9
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	4,095.5	3,888.0	207.5	94.9
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	89,653.6	83,717.3	5,936.4	93.4
		5	80233-Хүүхэд хамгаалал	4,412.2	3,099.9	1,312.3	70.3
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	31,495.2	30,899.0	596.2	98.1
		7	81823- Боловсролын багшийн сургалт	13,380.2	5,409.9	7,970.3	40.4
		8	81834- Боловсролын стандарт сургалт	1,798,919.4	1,533,425.5	265,493.9	85.2
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	75,537.2	69,517.1	6,020.1	92.0
		10	81848-Сурах бичгийн түрээс	1,577.4	1,337.4	240.0	84.8
		11	81875-мэдээлэл технологи	7,584.4	3,596.8	3,987.6	47.4

12	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	96,045.7	91,290.4	4,755.3	95.0
13	83602-ЗД нөөц хөрөнгөөс хуваарилсан	6,600.0	6,600.0	-	100.0
14	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	24.3	24.3	-	100.0
Нийт		2,137,964.5	1,840,142.0	297,822.4	86.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 76,010.4 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч гүйцэтгэгч ирээгүй учраас хоол хүнсийг “Шанзан ташуур” ХХК, “Уужим хараа” ХХК, “Амьд шим” ХХК, “Ноцох дөл” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ний Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,200,799.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,008.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт-2
- Дараа жилийн төсвийн төсөл-1

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр 4 багшид 763.8 мянган төгрөг олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, анхан шатны баримтын бүртэл дутуу 1,190.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

Төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	763.8	1	763.8	100.0
Зөвлөмж	1	1,190.7	1	1,190.7	100.0
Нийт дүн	2	1,954.5	2	1,954.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар нийт **2,344.6** мянган төгрөгийн зөрчил илэрч 2 төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаарын сарын 01-ний өдрийн 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч О.Жаргалмаа, нярав Б.Лхагважав нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 1,612.8 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь *"Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ"*, 14.2.3: *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"* гэсэн заалтууд болон; Засгийн газрын 2024 оны *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Улирлын амралттай хугацаанд бус хичээлийн жил эхлээгүй байхад буюу 8 дугаар сард 20 багшид анги даалтын нэмэгдэлд 731.8 мянган төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар *"Журамд өөрчлөлт оруулах тухай"* тушаалын 1 дэх *"Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Цалин илүү олгосон	2	2,344.6	2	2,344.6					
	1	2,344.6	1	2,344.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим санд 3 мэдээллийг хугацаа хоцроосон	1						1	
Нийт дүн	1						1	
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								